



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№59 /503/

2023.04.11

Цаг үе, үйл явдал

ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД Н.УЧРАЛ КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛД АЖИЛЛАЖ БАЙНА



Энэ цаг мөчид Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд дэслэгч генерал Г.Сайханбаяр, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нар Зэвсэгт хүчний Жанжин штаб, Зэвсэгт хүчний Кибер аюулгүй байдлын цэргийн командлалд

ажиллаж байна. Монгол Улсын Их хурлаар 2021 онд батлагдаж 2022 оны 5 дугаар сараас хэрэгжиж эхэлсэн Кибер аюулгүй байдлын тухай хууль, 2022-2023 оны заагт Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлагдсан Кибер аюулгүй

байдлын Үндэсний стратеги зэрэг бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах хүрээнд хийж гүйцэтгэх шаардлагатай ажил, арга хэмжээнүүдийн талаар хэлэлцэж, цаашид яам, агентлаг, командлалын түвшинд хамтран ажиллах боломжуудыг судлах,

зорилгоор Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал дагалдан яваа хүмүүсийнхээ хамт Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Кибер аюулгүй байдлын цэргийн командлалд ажиллаж, үйл ажиллагаатай нь танилцаж байна.



БНЭСУ-ААС МЭДЭЭЛЖ БАЙНА



“ДЭЛХИЙН ХҮНСНИЙ ХӨТӨЛБӨР”-ИЙН ЦУВАА ХАЛДЛАГАД ӨРТСӨНИЙГ ТАСЛАН ЗОГСООВ



хүнсний хөтөлбөр"-ийн хангалтын цувааны 3 дугаар цувраа болох 132 нэгж ачааны авто машин Бор-Юуай-Бор суурингийн чиглэлд алслагдсан суурин, тосгодог хүмүүнлэгийн тусламжийг хүргэх зорилгоор мотобуудлагын ротын хамгаалалтын бүрэлдэхүүний удирдлагад Этиоп улсын мотобуудлагын батальоны хамгаалалтын бүрэлдэхүүн хамтран үүргээ амжилттай гүйцэтгэлээ.

Бие бүрэлдэхүүн дөрөвдүгээр сарын 6-ны өдөр үндсэн үүргээ амжилттай дуусгаж байнгын байрлал руу Юуай-Бор суурингийн чиглэлд цуваа хөдөлгөөн үйлдэж эхэлсэн бөгөөд маршрутын дагуух Гадианг сууриныг өнгөрөн 27 километр орчим явж байх үед уг хүмүүнлэгийн цуваа руу орон нутгийн 20 гаруй зэвсэглэсэн этгээдүүд зам дагуух бутан дундаас чиглэсэн буудлага хийсний улмаас орон нутгийн гэрээт жолоочийн ачааны авто машин дээр дайгдаж явсан энгийн 3 иргэн шархадсан бөгөөд зэвсэгт этгээдүүд дээрэмдэх ажиллагаа явуулахыг завдсан юм.

Зэвсэгт хүчний мотобуудлагын ротын хамгаалалтын бүрэлдэхүүн буун дууг сонссон даруйд цагийн байдал үүссэн хэсэгт яаралтай очин шуурхай хариу арга хэмжээг авч хамгаалалтыг зохион байгуулсны үр дүнд халдлага үйлдсэн этгээдүүд зугтсанаар уг халдлагыг амжилттай зогсоосон юм. Түүнчлэн шархадсан иргэдэд эмнэлгийн яаралтай тусламжийг үзүүлж, амь насыг нь аварлаа.

Үргэлжлүүлэн “Бор” суурины “Сүбээдэй” баазаас нэмэлт эргүүлийн бүлгийг томилж, орон нутгийн эмнэлгийн татан гаргалтын бүлэг, цагдаагийн хамт цувааны аюулгүй байдлыг хангах, цагийн байдлыг тогтоох зорилгоор шуурхай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн ба шархадсан иргэдийг орон нутгийн эмнэлэг рүү амжилттай татан гаргасанд “UNMISS” ажиллагааны Зүүн секторын болон “Дэлхийн хүнсний хөтөлбөр”-ийн удирдлага мөн цуваанд явж байсан хүмүүнлэгийн ажилтнууд, жолооч нар баярласнаа илэрхийлсэн юм.

Ахлах дэслэгч Л.ТҮМЭНДЭЛГЭР

Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад хүнсний хомсдол үүсэж энгийн ард иргэдийн амьдрал ядуурал, өлсгөлөнд нэрвэгдэн, гэмт хэргийн гаралт нэмэгдэж байгаа бөгөөд НҮБ-ын энхийг сахиулах “UNMISS” ажиллагааны Зүүн секторын нутаг дэвсгэрт “Дэлхийн хүнсний хөтөлбөр”-өөс хүмүүнлэгийн ажиллагааг тасралтгүй

хэрэгжүүлсээр байна. Монгол Улсын цэргийн багаас Зүүн секторын “Бор” сууринд үүрэг гүйцэтгэж буй мотобуудлагын ротын бие бүрэлдэхүүн энэхүү “Дэлхийн хүнсний хөтөлбөр”-ийн цувааг хамгаалах үүргийг гүйцэтгэж байгаа юм. Энэ сарын нэгний өдрөөс 06-ны өдрүүдэд “Дэлхийн

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 5	☁️ -6

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 41	☁️ 29

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,497	3,505
EUR 🇪🇺	3,815	3,830
CNY 🇨🇳	511	514
RUB 🇷🇺	42.50	43.50
JPY 🇯🇵	26.60	27.00
KRW 🇰🇷	2.68	2.71

ЗУРХАЙ

2023.04.11 /МЯГМАР ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 20

ХАВРЫН ДУНД ХӨХӨГЧИН ТУУЛАЙ САР ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ ШАРАГЧИН ГАХАЙ ӨДӨР

Үс засуулбал:

Өлсөж ундаасна

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

06.12-19.35

Барилдлага:

Өтлөх

Шүтэн барилдлага:

Үхэхүй

Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Эл өдөр амь таслах, хор найруулах үйлнээ зэрэгчлэн бүтнэ, гэрийн үйл, бие угаах, хувцас өмсөхөд сайн. Баруун нүд татвал зочин ирэх, зүүн нь татвал хувцас олдох, баруун чих цангинавал баярлах, зүүн нь бол муу. Нохой уливал амгалан сайн болох, тагнай загатнавал дээрэм ирэх, бие татвал аюул болно.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 685,026,479

Эдгэрсэн

Нийт: 657,857,732

Нас барсан

Нийт: 6,838,034

